

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХОЙД БҮС ДЭХ
ГАЗРЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН
/2019.09.26-2019.10.25/

2019 оны 10 дугаар сарын 25

Сүхбаатар сум

Тус газар нь 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол улсын хилийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоол, 2018 оны 145,146 дугаар тогтоолоор батлагдсан журмууд болон байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Орон нутагт дахь газрын ажиллах журам”, “Ажил үйлчилгээний стандарт”-ыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж төрийн үйлчилгээг өөрийн орны болон гадаадын иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэн, төрийн албыг зохих түвшинд зохион байгуулан ажиллаж байна.

2019 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ: Сургалт, хурал зөвлөгөө

Байгууллагаас зохион байгуулсан 1 удаагийн онлайн хурал, тус газраас зохион байгуулсан 4 удаагийн хамт олны хурлыг зохион байгуулж цаг үеийн байдлын талаар тодорхой үүрэг чиглэл авч ажилласан.

ХОЁР: Хүний нөөцийн талаар

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2019 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутаг дахь газрын ажиллах журам”, “Байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм”, “Байгууллагын ажил үйлчилгээний стандарт”, “Албан тушаалын тодорхойлолт” болон бусад хууль, тогтоомжийг ажил үүрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус газрын 2019 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу газрын дарга Б.Мөнхбатын ээлжийн амралтыг 10 дугаар сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал ажлын 22 өдрөөр, захиргааны мэргэжилтэн Г.Ариунзаяа, мэргэжилтэн Б.Элбэгзаяа, жолооч Э.Ууганбаяр нарын ээлжийн амралтыг 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийг дуустал ажлын 15 өдрөөр тус тус зохих журмын дагуу олгосон болно. Мөн хяналтын улсын байцаагч Ч.Бямбаа нь байгууллагын даргын баталсан 2019 оны хилийн боомтод ажиллах ээлжийн хуваарийн дагуу 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Ханх” авто замын боомтод үүрэг гүйцэтгэж байна.

ГУРАВ: Ирсэн явсан албан бичиг, өргөдөл гомдлын талаар

Тус газарт төвөөс болон бусад байгууллагаас нийт 14 албан бичиг ирснээс хариутай 7 албан бичгийн хариуг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд хугацаа хоцорсон болон шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа албан бичиг байхгүй болно. Тус газраас 13 албан бичиг бусад байгууллагад хандаж явуулсан байна.

Тайлант хугацаанд тус газрын албан хаагчдаас чөлөө хүссэн 3 өргөдөл ирснийг газрын дарга танилцаж, шийдвэрлэж ажилласан.

Тус газарт албан хаагч ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн гэж 4 албан хаагч сахилгын талон цоолуулсан байна. Үүнд: Хяналтын улсын ахлах байцаагч С.Мөнх-Эрдэнэ, Дархан-Уул аймаг дахь ахлах мэргэжилтэн О.Хэрлэн, Орхон аймаг дахь ахлах мэргэжилтэн О.Мөнхбат, Архангай аймаг дахь ахлах мэргэжилтэн Б.Уламбаяр, мөн хяналтын улсын байцаагч Ч.Бямбаа нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хилийн боомт дахь ажлын байраа дур мэдэн орхин явсан зөрчил гарган сануулах сахилгын шийтгэл, Архангай аймаг дахь ахлах мэргэжилтэн хяналтын улсын байцаагч Б.Уламбаяр ажил үүрэгтээ хайхрамжгүй хандан ажил үүргээ цалгардуулан албан тушаалын цалинг 3 сарын цалингийн 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл тус тус оногдуулсан байна.

ДӨРӨВ: Виз, бүртгэлийн талаар

Виз олголт:

Хойд бүс дэх газрын хэмжээнд 2019 оны 09 дугаар сарын 26-ны өдрөөс 10 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу 20 орны 65 иргэнд зохих ангилал, зориулалтын визийг зохих зөвшөөрлөөр олгож ажиллаа. Үүнд:

АНУ-1, Бельги-6, Азербайжан-6, Бангладеш-12, Болгар-1, БНКаЗУ-1, Литва-1, БНМолдав-3, Польш-1, БНСУ-1, Филиппин-1, Франц-2, БНХАУ-8, ӨАБНУ-1, Иран-2, Испани-7, ИБУИНВУ-5, ОХУ-7, Португаль-1, ХБНГУ-1, Швейцарь-1 иргэн байна. Олгосон визийг төрөл, зориулалтаар нь авч үзвэл: нэг удаагийн орох виз-44, нэг удаагийн гарах-орох виз-7, дамжин өнгөрөх виз-14 байна.

Визийн хураамж 5,544,000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан.

Хил орчмын зорчих үнэмлэхээр зорчигч иргэдийн хяналт:

Хялбарчилсан журмаар хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй ОХУ-ын 96 иргэнд бүртгэл хийсэн.

Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 8 орны 44 иргэнд бүртгэл, хасалт хийн, бүртгэлийн хураамж 61,000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Үүнд: АНУ-3, Азербайжан-1, БНХАУ-18, Иран-2, Кыргыз-1, ОХУ-16, Украин-2, Бразил-1 иргэн байна.

Оршин суух зөвшөөрөлтэй иргэдийн хасалт:

Тайлант хугацаанд албан хүсэлтийн дагуу 5 орны 46 иргэний оршин суух үнэмлэхийг хураан авч, хасалт хийсэн байна. Үүнд: БНАзербайжан-1, БНХАУ-42, БНСУ-1, БНИрланд-1, ОХУ-1 иргэн байна.

Алдаатай олгогдсон виз: Байхгүй.

ТАВ: Хяналт, шалгалтын талаар

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 1-05/10 дугаар удирдамжийн хүрээнд Хойд бүс дэх газрын даргын баталсан ХБГ-14/18 дугаар удирдамжийн дагуу 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд уул уурхай, барилга, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр 34 аж ахуй нэгж, байгууллагын 6 орны 414 иргэний бичиг баримтад хяналт шалгалт хийсэн. дараах хяналт шалгалтыг зохион байгууллаа. Үүнд:

Сэлэнгэ аймгийн Хүдэр сум, Булагтай 1 дүгээр баг, “Эрдэс холдинг” ХХК-ийн нойтон хүдэр баяжуулах үйлдвэрийн талбайд 09 дүгээр сарын 23-ны өдөр хийсэн хяналт шалгалтаар БНХАУ-ын иргэн Yang Changbo, Yang Changtao нар нь 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр “J” ангиллын 30 хоногийн байх хугацаатай, нэг удаагийн орох зориулалттай визтэй Замын-Үүд авто замын боомтоор орж ирэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болох нь Yang Changbo, Yang Changtao нарын гадаад паспорт дахь MNG0133818, MNG0133819 дугаартай виз болон зөрчлөө хүлээн зөвшөөрөн бичгээр гаргасан тайлбар, хяналт шалгалтын явцад авсан фото зураг зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож байна.

БНХАУ-ын иргэн Yang Changbo, Yang Changtao нарын Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн үйлдэлд нь Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт зааснаар тус бүр 100,000 /нэг зуун мянган/ төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7-д тус тус зааснаар 3 жилийн хугацаанд орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргах саналыг хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/270 дугаар захирамжийн дагуу 08 дугаар сарын 21-ний өдрөөс 31-ний өдрийн хооронд хууль, хяналтын байгууллагуудын хамтарсан хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, нөхөрлөлийг албадан буулгах, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн бөгөөд хууль бусаар үйл ажиллагаа явуулж байсан иргэн, аж ахуй нэгж, компани, нөхөрлөлүүдийн хүнд машин механизм, техник, хэрэгслүүдийг лацдаж, битүүмжилсэн болно.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар:

Хойд бүс дэх газрын даргын баталсан 14/15 тоот удирдамжийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хяналтын улсын байцаагч Б.Ганзориг, сүлжээний инженер Э.Наранбат, Сэлэнгэ аймаг дахь тагнуулийн газрын ажилтан а/д н.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэй Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Нарангийн гол гэх газарт байрлах Угалз хөндий хоршоонд БНХАУ-ын иргэд хууль бусаар ажиллаж байна гэсэн мэдээллийн дагуу тухайн газарт Сэлэнгэ аймаг дахь тагнуулийн газрын ажилтан а/д н.Ганбаяр, сүлжээний инженер Э.Наранбаттай цуг БНХАУ-ын 3 иргэний баримт бичгийг шалгахад БНХАУ-ын иргэн Yan Shoudei нь “J” ангиллын визтэй, БНХАУ-ын иргэн Kong Wuhai нь В ангиллын визтэйгээр 2019 оны 10 дугаар сарын 14 өдөр Замын-Үүдийн төмөр замын боомтоор хил нэвтрэн орж ирсэн.

БНХАУ-ын иргэн YAN SHOUDEI , KONG WUHAI нартай холбогдох хэргийн ажиллагааг явуулж байна.

Оногдуулсан торгох шийтгэлийн тухайд:

Тайлангийн хугацаанд зөрчлийн хэрэг нээгээгүй. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 22 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хуулиар зөрчил гаргасан 6 орны 18 иргэнд 1.840.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд: АНУ-1, Франц-1, БНХАУ-3, Украин-1, ОХУ-10, Бразил-2 иргэн байна.

Гадаадын иргэний урьсан 3 аж ахуй нэгж, байгууллагад 670.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Торгох шийтгэл оногдуулсныг хүснэгтээр үзүүлбэл:

Газрын нэр	Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
	Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
ХБГ	22	1.840.000	3	4	670.000	-	-	-
Хувь хүнээр 18 гадаадын иргэнд, уригч байгууллагаар 3 аж ахуйн нэгж, байгууллага /4 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл оногдуулж, нийт 2 сая 5 зуун 10 мянган /2.510.000/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.								

Монгол Улсаас албадан гаргасан талаар: Тайлангийн хугацаанд БНХАУ-2, ОХУ-1 иргэнийг албадан гаргасан.

№	Улс	Зүйлчлэл				Нийт
		37.1.3	37.1.7	37.1.11	37.1.12	
1	БНХАУ		2			7
2	ОХУ	1				
БҮГД		1	2			7

Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар: Монгол Улсад орох визгүй болон хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилго тодорхойгүй 9 орны 29 иргэнийг ГИЭЗБТХуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд тус тус заасны дагуу хил нэвтрүүлэлгүй буцааж ажилласан. Үүнд: Азербайжан-1, Армен-3, Беларус-2, Казакстан-4, Серби-2, Узбекстан-2, Кыргыз-4, ОХУ-6, Украин-5 иргэн байна.

ЗУРГАА: Мэдээлэл технологийн талаар

Тайлант хугацаанд ОХУ-ын 1 иргэний хурууний хээний бүртгэл хийн, оршин суух мэдээллийн бүртгэлийг хангасан. Хилийн боомтоор орох, гарах чиглэлд зорчсон гадаадын иргэдийн бүрдүүлэх материалын 14 ширхэг цээж зургийг гаргаж ажилласан. Төвөөс ирүүлсэн “Drone Pantom 4 pro plus” болон агаарийн бичлэг, фото

зургийн төхөөрөмжүүдийг 1 удаагийн хяналт шалгалтаар ашиглаж, хяналтын шалгалтаар явсан зургийг файлжуулсан. Сүхбаатар төмөр замын боомтын камерын төхөөрөмжийн сүлжээний утсыг шинэчилсэн. Алтанбулаг авто замын боомтын камерын хар хайрцагаас бичлэгийг файлжуулж, мөн хяналт шалгалтаар явсан хяналтын улсын байцаагч нарын энгэрийн хар хайрцагын файлыг виз зөвшөөрлийн ахлахын компьютерт хуулж архивлуулан ажиллаж байна.

ДОЛОО: Бусад ажлын талаар

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд “Хилийн Алтанбулаг боомтын авто зам, авто зогсоолын барилга угсралтын ажил” шав тавих ажиллагаанд 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хилийн хамтран ажилладаг байгууллагуудтай оролцож Газрын дарга Б.Мөнхбат, хяналтын улсын ахлах байцаагч С.Мөнх-Эрдэнэ, хяналтын улсын байцаагч Б.Ганзориг, мэргэжилтэн Б.Батцэцэг, Л.Энх-Амгалан, Р.Батзаяа, Б.Отгон Э.Мөнгөнцэцэг нар оролцсон.



Мөн тус өдөр “Сүхбаатар төмөр замын боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилга угсралтын ажил” –ын шав тавих үйл ажиллагаа болсон.



Нярав О.Өсөхбаяр нь 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгууллагынхаа албан хаагчдад “Өөртөө амлалт авч амлалтандаа хүрэх, өөртөө итгэх итгэл”, “Стрессээ даван туулах, уур бухимдлаа барих” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи Сэлэнгэ аймагт 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Төрийн албаны

сургалтын бодлого тогтолцоо, өөрчлөлт, шинэчлэлт”, “Албан тушаалын тодорхойлолт”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах нь”, “Албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтанд мэргэжилтэн Р.Батзаяа, Б.Отгон, Э.Мөнгөнцэцэг нар хамрагдсан.



Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Хуулийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг”-т хяналтын улсын байцаагч П.Бороо, мэргэжилтэн Ш.Чулуун-Эрдэнэ, Б.Отгон нар өөрийн байгууллагын талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Сүхбаатар боомт дахь “Хилийн мэргэжлийн хяналтын алба”-аас 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Монгол улсын хууль тогтоомжийг улсын хил дээр хэрэгжүүлэх” бизнес эрхлэгч аж ахуй нэгж байгууллагад зөвлөмж зөвлөгөө өгөх сургалтанд мэргэжилтэн Ш.Чулуун-Эрдэнэ хамрагдсан.



Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газраас 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Архи, тамхигүй эрүүл ажлын байр” сэдэвт сургалтанд 8 албан хаагч хамрагдсан.

